



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 21 өдөр

Дугаар A/154

Бор-Өндөр сум

**Орон нутгийн хөгжлийн сангаас
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх хэсэг, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дахь хэсэг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар Тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр суманд “Ухаалаг усан сан” худалдан авахаар гэрээ байгуулсан “Баялаг говь”-ХХК-д үлдэгдэл 50%-н санхүүжилт болох 47,377,800 (дөчин долоон сая гурван зуун далан долоон мянга найман зуу) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын үлдэгдэл санхүүжилт болох 47,377,800 (дөчин долоон сая гурван зуун далан долоон мянга найман зуу) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ